

БАЙГАЛЬ ОРЧИНД УЧРУУЛСАН ХОХИРЛЫГ ТООЦОЖ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ, ХАРИУЦЛАГА НОГДУУЛАХ ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

*Р. Хатанбаатар, А. Пагма,
Р. Нургүл, Г. Алтан-Оч (Ph.D)*

БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

Байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлж хариуцлага хүлээлгэх талаар

Солонгос улсад байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, хариуцлага хүлээлгэх асуудлыг Байгаль орчныг хамгаалах тухай (Natural Environment conservation act) хуулиар¹²³ зохицуулдаг.

Хуулинд зааснаар байгаль экологийн хамгаалалттай бүс, байгалийн үзэсгэлэнт газар болон түүний ойр орчмын бүсэд хохирол учруулах аливаа үйл ажиллагааг хориглодог. Үүнд:

- Ямар нэг арга хэрэглэж амьтан, ургамлыг хөнөөх, тухайлбал, ургамлын зүйлийг түүх, шилжүүлэн суулгах, гэмтээх, мөн тэсрэх бөмбөг, гох дэгээ, тор, урхи ашиглаж ан амьтныг барих, гэмтээх, хөнөөх, эсвэл химийн бодис, хор ашиглаж амьтан, ургамлыг хөнөөх гэх мэт.
- Барилга байгууламж барих, өргөжүүлэх үйл ажиллагааны улмаас газрын төрх байдал болон чанар алдагдах;
- Гол, нуурын хэлбэр, усны түвшин болон хэмжээ өөрчлөгдөх;
- Хөрс шороо, чулууг ашиглах;
- Байгаль орчинд хор хохирол учруулах бусад үйл ажиллагаанууд орно.

Зөвхөн онцгой тохиолдол буюу цэрэг дайны зорилгоор, байгалийн гамшгийн улмаас, байгаль экологийн хамгаалалтын бүс болон байгалийн үзэсгэлэнт газар оршин суугаа хүмүүсийн амьдрал ахуйг дэмжих болон бусад онцгой тохиолдолд л Ерөнхийлөгчийн зөвшөөрлөөр дээрх үйл ажиллагааг явуулж болно.

Хэрэв хууль дүрэм зөрчиж байгаль орчинд хохирол учруулсан бол хорих ялаар шийтгүүлэх, эсвэл мөнгөн торгууль төлөх шийтгэлтэй байдаг.

1. Дараах байдлаар байгаль орчинд хохирол учруулбал 3 жил хүртэл хорих ялаар шийтгүүлэх, эсвэл 20 сая хүртэл вонны мөнгөн торгууль төлнө. Үүнд:

- Байгаль экологийн хамгаалалттай бүс болон байгалийн үзэсгэлэнт газар байгаль орчинд хохирол учруулсан бол;
- Байгаль экологийн хамгаалалттай бүс болон байгалийн үзэсгэлэнт газрын орчин тойрны бүсэд байгаль орчинд хохирол учруулсан бол;
- Экологийн хамгаалалттай бүс болон байгалийн үзэсгэлэнт газар үйл ажиллагаа явуулдаг байгууллага, хүний үйл ажиллагааг зогсоох, эсвэл тодорхой хугацаанд байгаль орчныг нөхөн сэргээх, нөхөн сэргээх нь хүнд хэцүү бөгөөд боломжгүй бол нөхөн сэргээхийг орлохуйц ямар нэг арга хэмжээ авах зэрэг Байгаль орчны яамнаас гаргасан шийдвэрийг биелүүлээгүй зэрэг орно.

2. Байгаль экологийн хамгаалалттай бүс болон байгалийн үзэсгэлэнт газрын шилжилтийн бүсэд (transition area) байгаль орчинд хохирол учруулсан бол 2 жил хүртэл хорих ялаар, эсвэл 10 сая хүртэл вонны мөнгөн торгуулиар шийтгүүлнэ.

¹²³Natural Environment conservation act. http://elaw.klri.re.kr/eng_mobile/

Хуулийн этгээд болон аж ахуйн нэгжийн төлөөлөгч, төрийн албан хаагч болон хуулийн этгээдэд ажилладаг ажилтан, хувь хүн байгаль орчинд хохирол учруулсан бол тухайн хүн дээр дурдсан хорих ял, мөнгөн торгуулиар шийтгүүлэхээс гадна түүний ажилладаг байгууллага мөн хариуцлага хүлээнэ.

3. Байгаль экологийн хамгаалалттай бүс болон байгалийн үзэсгэлэнт газрыг хамгаалах талаар хотын дарга, эсвэл Засаг даргын гаргасан шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд 10 сая вонн хүртэл мөнгөн торгууль ногдуулна.

4. Дараах тохиолдолд 2 сая вонн хүртэл мөнгөн торгуулиар шийтгүүлнэ. Үүнд:

- Байгалийн үзэсгэлэнт газар болон байгаль экологийн хамгаалалттай бүсэд усны чанарт нөлөөлөх аюултай бодис, хог хаягдал, хорт бодис хаях; шатамхай бодис байлгах, аялал зугаалгаар явж, хоол унд хийх; байгаль орчныг хамгаалах тэмдэг, тэмдэглэгээ бүхий самбарыг будах, гэмтээх, байрнаас нь зөөх; өвс ногоо таслах, мод огтлох зэргээр байгаль орчинд хохирол учруулах (Зөвхөн цэрэг дайны зорилгоор, байгалийн гамшгийн улмаас болон Ерөнхийлөгчийн зөвшөөрөл олгосон тохиолдолд л эдгээр үйл ажиллагааг зөвшөөрнө);
- Хуулийн дагуу зөвшөөрөлтэй хүн байгаль орчныг хамгаалах зорилгоор бусдын эзэмшил газар нэвтрэх эрхтэй байдаг бөгөөд зөвшөөрөгдсөн үйл ажиллагаануудыг явуулах боломжтой. Тухайн газрын эзэн үүнийг эсэргүүцэж биелүүлэхгүй байх;
- Мод бэлтгэх, газрын төрх байдал, чанарт нөлөөлөх үйл ажиллагаа явуулах, газар ашиглах, аялал зугаалга хийж хоол бэлтгэх зэрэг үйл ажиллагааг Орон нутгийн засаг захиргаанаас байгаль орчинд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хязгаарлах шийдвэр гаргасныг биелүүлээгүй зэрэг тохиолдлууд орно.

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

Тус улсад 2002 онд батлагдсан “Хүрээлэн буй орчныг хамгаалах тухай”¹²⁴ хуулийн 16 дугаар бүлэгт хүрээлэн буй орчныг хамгаалах тухай хууль, тогтоомжийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тухай заасан.

Уг хуулиар хүрээлэн буй орчны чанарын норм, норматив, байгаль орчинд нөлөөлөх бүх нөлөөллийн нормативыг тогтоосон байдаг ба тэдгээрийн дагуу байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, экологийн хяналт, шалгалт хийгдэж учруулсан хохирлыг тооцдог байна.

Энэхүү хуулийн 75 дугаар зүйлд хүрээлэн буй орчныг хамгаалах тухай хууль, тогтоомжийг зөрчсөн тохиолдолд эд хөрөнгийн, сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлагыг хууль, тогтоомжийн дагуу хүлээлгэх тухай зааж хариуцлагын хэлбэрийг тодорхойлсон.

Дээр дурдсан хуулийн 77 дугаар зүйлд хүрээлэн буй орчинд хохирол учруулсан хувь хүн, хуулийн этгээд хууль, тогтоомжийн дагуу уг хохирлыг заавал бүрэн дүүрэн нөхөн төлөх үүрэгтэй болохыг хуульчилсан байна.

Түүнчлэн байгаль орчинд учруулсан хохирлыг хэрхэн тооцож, нөхөн төлүүлэх талаар хуульчилсан. Ингэхдээ аж ахуйн ба бусад үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхдээ тогтоогдсон журмын дагуу батлагдсан татвар хураамж, байгаль орчинд учруулсан хохирлын хэмжээг тооцох аргачлалын дагуу, хэрэв ийм хураамж, аргачлал үгүй бол байгаль орчныг нөхөн сэргээхэд гарсан бодит зардлыг алдагдсан ашгийн хэмжээтэй хамтатган тооцож нөхөн төлүүлнэ.

¹²⁴ФЗ “О защите окружающей среды”. <http://base.garant.ru/>

Мөн хуулиар байгаль орчинд учруулсан хохирлыг сайн дурын үндсэн дээр ба шүүхийн шийдвэрийн дагуу нөхөн төлүүлэхийг заасан. Хүрээлэн буй орчныг хамгаалах тухай хууль, тогтоомжийг зөрчиж, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаарх нэхэмжлэлийг 20 жилийн хугацаанд гаргаж болно.

Төрийн өмчлөлийн байгалийн объектод учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхдээ ихэнх төлөв Хүрээлэн буй орчныг хамгаалах Улсын Хорооноос баталсан “Экологийн зөрчлийн улмаас байгаль орчинд учруулсан хохирлын хэмжээг тооцох аргачлал”-ын¹²⁵ дагуу мөнгөн төлбөрийг тогтоохдоо байгаль орчныг нөхөн сэргээхэд гарсан бодит зардлыг алдагдсан ашгийн хэмжээтэй хамтатган тооцож нөхөн төлүүлнэ. Жишээ нь: Тус Аргачлалын 4.5-д агаар мандлыг бохирдуулсны нөхөн төлбөрийг тооцохдоо агаар мандалд ууршиж замхарсан бохирдуулагч бодисын нийт хэмжээгээр тооцоно. Бохирдуулагч бодисын хэмжээг хүчин төгөлдөр хэрэглэгдэж байгаа аргачлалын дагуу тооцооны ба шинжилгээний аргаар тодорхойлно гэж заажээ¹²⁶.

Тогтсон үнэлгээгүй байгалийн объектод учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхдээ хохирлыг тооцох таксийн арга буюу хураамжийн аргыг ашигладаг байна. Ингэхдээ хууль бусаар устгаж сүйтгэсэн байгалийн объект нэг бүрийг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоон, үүнийг стандарт болгон мөрдөнө. Энэхүү стандартыг экологийн онцгой аюултай объект болох ойн сан, амьтны аймгийн объект, усны биологийн нөөцөд хохирол учруулсан нөхцөлд мөрддөг.

Такс буюу хураамж нь иргэний эрх зүйн хариуцлагын хүрээнд байгальд учруулсан хохирлыг тооцох арга бөгөөд түүнийг байгальд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх загварчилсан хэмжээ гэж үздэг ажээ.

Хураамж тогтоох аргын онцлог нь зөвхөн учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх бус, хууль зөрчигчдийг шийтгэх зорилгыг агуулдаг учраас нөхөн төлбөрийн хэмжээг сүйтгүүлж, устгагдсан байгалийн объектын үнээс байнга өндөр тогтоодог.

Тухайлбал, ОХУ-ын Засгийн газрын 2007 оны 273 дугаар Тогтоолоор батлагдсан ойн сан, ойн санд бүртгэгдээгүй ойд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх хэмжээг тооцох хураамжийн дагуу зарим төрлийн мод, суулгацийг хууль бусаар огтолсоны нөхөн төлбөрийг ийм төрлийн мод тармилын нэг бүрийн үнийг 50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн дүнгийн хэмжээгээр тооцохыг тогтоосон байна.¹²⁷

Дээр хүрээлэн буй орчныг хамгаалах тухай хууль, тогтоомжийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын хэлбэрийн талаар дурдсан.

Тухайлбал, ОХУ-ын Захиргааны хариуцлагын тухай хуулийн 8 дугаар бүлэгт хүрээлэн буй орчныг хамгаалах тухай хууль, тогтоомжийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх захиргааны хариуцлагын талаар хуульчилсан. Жишээ нь, усны хамгаалалт бүхий газар газар, ойг ашиглах журмыг зөрчсөн тохиолдолд иргэнд 3000-5000 руб., албан тушаалтанд 40000-50000 руб., хуулийн этгээдэд 200000-300000 рублийн торгууль ногдуулах эсвэл 90 хүртэл хоногоор үйл ажиллагааг нь захиргааны журмаар зогсоох, хуулийн этгээлийн статусгүйгээр бизнесийн үйл ажиллагаа явуулж буй этгээдэд 40000-50000 рублийн торгууль ногдуулах

¹²⁵Методические указания по оценке и возмещению вреда, нанесенного окружающей природной среде в результате экологических правонарушений. base.consultant.ru

¹²⁶Мөн тэнд.

¹²⁷Постановление Правительства РФ от 26.11.2007 г. N 273 «Об утверждении такс для исчисления размера взысканий за ущерб, причиненный лесному фонду и не входящим в лесной фонд лесам нарушением лесного законодательства РФ». base.consultant.ru

эсвэл 90 хүртэл хоногоор үйл ажиллагааг нь захиргааны журмаар зогсоох захиргааны арга хэмжээ авахаар хуульчилсан байна.¹²⁸

Түүнчлэн ОХУ-ын Эрүүгийн хуулийн онцгой ангийн 9 дүгээр хэсгийн 26 дугаар бүлэгт экологийн гэмт хэрэгт ногдуулах эрүүгийн хариуцлагыг хуульчилжээ. Тухайлбал, 250 дугаар зүйлд хөрсний, гүний, ундны ус бохирдуулсан, ширгээсэн, байгалийн шинж чанарыг нь алдагдуулсан, эдгээр үйлдлийн улмаас ургамал, амьтны аймаг, ой, хөдөө аж ахуйд ихээхэн хохирол учруулсан тохиолдолд 80000 хүртэл рубль буюу эсвэл гэмт хэрэгтний 6 сар хүртэлх хугацааны цалин, түүнтэй тэнцэх орлогтой тэнцэх мөнгөөр торгох, эсвэл 5 жил хүртэлх хугацаагаар тодорхой албан тушаал хаших, үйл ажиллагаа явуулах эрхийг нь хасах, эсвэл 360 хүртэл цагаар албадан хөдөлмөр эрхлүүлэх, эсвэл 3 сар хүртэл хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулахаар хуульчилсан байна.¹²⁹

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС

БНХАУ-ын байгаль орчныг хамгаалах тухай хууль¹³⁰

Уг хуулийг 1989.12.26-ны өдөр баталсан. 6 бүлэг, 47 заалттай.

1-р зүйл: Ерөнхий зүйл; 2-р бүлэг: Байгаль орчны хяналт шалгалт, удирдлага; 3-р бүлэг: Байгаль орчныг хамгаалах, сайжруулах; 4-р бүлэг: Байгаль орчны бохирдол болон бусад нийтийг хамарсан аюул эрсдлээс урьдчилан сэргийлэх, хяналт тавих; 5-р Эрхзүйн хариуцлага; 6-р бүлэг: Бусад гэсэн бүлгүүдээс бүрдэнэ.

Хуулийн 5-р зүйлд, байгаль орчныг хамгаалах чиглэлийн шинжлэх ухааны боловсролыг хөгжүүлэх, шинжлэх ухаан, технологийн судалгаа шинжилгээг эрчимжүүлэх, түүний төвшнийг нэмэгдүүлэх, шинжлэх ухааны мэдлэгийг нийтийн хүртээл болгохыг төр хөхиүлэн дэмжинэ гэж заажээ.

6-р зүйлд, бүх байгууллага, хувь хүн байгаль орчныг хамгаалах үүрэгтэй бөгөөд байгаль орчин бохирдуулсан буюу түүнд хохирол учруулсан байгууллага, хувь хүний эсрэг зарга мэдүүлэх эрхтэй гэж заасан байдаг.

Төрийн зөвлөлийн дэргэдэх байгаль орчны хамгаалалтын захиргааны эрх бүхий газар нь байгаль орчны чанарын үндэсний стандартыг бий болгоно. Төв засгийн газрын шууд удирдлага дор байх муж, автономит бүс, хотын захиргааны ардын засгийн газар нь үндэсний стандартад тусгагдаагүй асуудлаар өөрийн стандартыг тогтоож болох ба үүнийгээ дээрх байгууллагад тайлагнах үүрэг хүлээнэ. Мөн дээрх газар нь хяналтын системийг бий болгож, хяналтын нормативыг тогтоохоос гадна холбогдох газартай хамтран хяналтын сүлжээг зохион байгуулж, байгаль орчны хяналтын удирдлагыг боловсронгуй болгоно. Уг газар болон засгийн газрууд байгаль орчны нөхцөл байдлын талаар тогтмол тайлан мэдээлэл гаргаж байна.

Байгаль орчныг бохирдуулахуиц барилгын төслийн нэгжүүд нь байгаль орчин хамгаалах хууль тогтоомжуудыг мөрдөх шаардлагатай. Төлөвлөлтийн газар нь барилгын төслийн байгаль орчинд нөлөөлөх үнэлгээ хийгдэж зөвшөөрөл авах хүртэл барилгын төслийн зохион бүтээлтийн нарийвчилсан төлөвлөгөөг батлахгүй.

¹²⁸Кодекс об административных правонарушениях (КоАП РФ). Ст.8.12. <http://base.garant.ru/>

¹²⁹Уголовный кодекс (УК РФ) > Особенная часть >. Раздел IX. Глава 26. Ст.250. <http://base.garant.ru/>

¹³⁰www.china.org.cn/english/environment/34356.htm

Төрөл бүрийн төвшний ардын засгийн газрууд нь өөрийн харъяалах нутгийн байгаль орчны чанарыг хариуцах ба сайжруулах арга хэмжээ авах үүрэгтэй. Эдгээр засгийн газрууд нь байгаль экологийн төрөл бүрийн систем бүхий бүс нутаг, ховор болон устаж буй зэрлэг амьтан, ургамал бүхий бүс нутаг, усны үндсэн эх үүсвэрийг хадгалсан бүс нутаг, шинжлэх ухаан, соёлын хувьд үнэ цэнэ бүхий геологийн тогтоц, алдартай агуй, органик биетийн чулуужсан үлдэгдэл бүхий бүс нутаг, мөсөн гол, галт уул, халуун рашаан, хүн төрөлхтний түүхэн ул мөр, эртний болон ховор модыг тус тус хамгаалах үүрэгтэй. Дээрх зүйлүүдийг гэмтээхийг хатуу хориглоно.

Байгалийн үзэсгэлэнт, эсвэл түүхт газар, дархан цаазат болон бусад Төрийн зөвлөл болон түүний дэргэдэх эрх бүхий газар, цаашилбал, муж, автономит бүс нутаг болон Төв засгийн газарт шууд харъяалагдах хотын захиргааны ардын засгийн газрын тогтоосон хамгаалалт шаардлагатай бүсийн дотор байгаль орчин бохирдуулахуйц үйлдвэрлэлийн байгууламж барьж болохгүй; тогтоосон бохирдлын стандартаас хэтрэхгүй бол бусад байгууламж барьж болно. Нэгэнт баригдсан байгууламжийн ялгаруулах бохирдол стандартын хэмжээнээс давбал түүнийг тодорхой хугацааны дотор арилгах буюу хянаж байх шаардлагатай.

Хэрэв байгалийн баялаг боловсруулах буюу олборлож байгаа бол байгаль орчны экологийг хамгаалах үүднээс зохих арга хэмжээнүүдийг авсан байвал зохилтой.

Бүх төвшний ардын засгийн газар нь хөрсний бохирдол, газар цөлжилт болон шүлтжилт, хөрсийг сайжруулах, газрын намагжин доройтолт, хөрсний гулгалт, ургамлын гэмтэл, хөрсний эвдрэл, усны нөөцийн хаталт, төрөл зүйлийн мөхөл болон бусад экологийн тэнцвэрт байдал алдагдахаас урьдчилан сэргийлэх буюу хянах замаар, ургамлын өвчин, хортон шавьжийг бүр мөсөн урьдчилан сэргийлэх буюу хянах замаар, химийн бордоо, пестицид болон ургац нэмэгдүүлэх гормоныг үр ашигтай хэрэглэх замаар тариалангийн байгаль орчныг илүү сайн хамгаалах үүрэгтэй.

Хотод болон орон нутагт барилга байгууламж барихдаа ургамал, ус, байгалийн ландшафтыг хамгаалах бөгөөд тухайн байгаль орчны онцлогт тохирсон цэцэрлэгт хүрээлэн, ногоон бүс болон түүхт газар, байгалийн үзэсгэлэнт газар байгуулахад анхаарна.

Байгаль орчны бохирдол болон нийтийг хамарсан аюул эрсдэл үүсгэх бүх байгууллага нь үйлдвэрлэл явуулах, барилга байгууламж барих болон бусад үйл ажиллагааны улмаас үүсэх бохир хий, бохир ус, бохир хаягдал, тоос, өмхий хий, цацраг идэвхт бодис, шуугиан, чичиргээ, цахилгаан соронзон цацрагийн нөлөөгөөр байгаль орчинд учрах бохирдол, хохирлоос урьдчилан сэргийлэх буюу хянах үр дүнтэй арга хэмжээ авч, байгаль орчны хамгааллын хариуцлагын системийг бий болгож, байгаль орчныг хамгаалах асуудлыг төлөвлөгөөндөө тусгаж ажиллах үүрэгтэй.

Шинээр байгуулах үйлдвэр болон оршин байгаа үйлдвэрийн газарт технологи дамжуулахдаа түүхий эдийг дээд зэргээр ашигладаг, байгаль орчинд хамгийн бага хор хөнөөлтэй тоног төхөөрөмж, технологийн процессыг ашиглах ба хаягдал материалыг бүр мөсөн ашигладаг, бохирдлыг цэвэршүүлдэг эдийн засгийн үр ашигтай, хэмнэлттэй технологийг ашиглах үүрэгтэй.

Үндэсний болон орон нутгийн байгаль орчны бохирдлын стандартын шаардлагаас хэтрүүлэн бохирдуулсан бүх үйлдвэр, байгууллага нь тогтоосон хэмжээний татвар төлөх ба бохирдлыг арилгах болон хянахад хариуцлага хүлээнэ. Хэрэв шаардлагатай бол Усны бохирдлоос урьдчилан сэргийлэх болон түүнийг хянах тухай хуулийг ч хослуулан мөрдөнө. Бохирдол ялгаруулалтын стандартыг хэтрүүлсэнээс орох татварын орлогыг зөвхөн бохирдлоос урьдчилан сэргийлэх болон хянах зорилгоор ашиглах ба бусад ямар ч зорилгоор үрэхгүй. Энэ тухайд Төрийн зөвлөлөөс тусгайлан арга хэмжээ авна.

Байгаль орчны хамгаалалтын журамд тусгасан шаардлагыг хангахгүй технологи, тоног төхөөрөмжийг импортлоход торгууль ногдуулна.

Цацраг идэвхт бодис агуулсан хортой химийн бодис болон материал үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, борлуулах болон хэрэглэхэд холбогдох төрийн хууль тогтоомжийг хослуулан мөрдүүлнэ.

Бохирдлыг нь урьдчилан сэргийлэх буюу хянах боломжгүй, түүнийг хэрэглэснээр асар их бохирдол гаргадаг үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг нэг этгээдээс нөгөөд шилжүүлэхийг зөвшөөрөхгүй.

БНХАУ-ын ашигт малтмалын тухай хууль¹³¹

Уг хууль нь 1986.10.01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон, 1996 онд өөрчлөлт оруулсан. Нийт 7 бүлэг, 53 зүйлтэй. Ашигт малтмалын хайгуулын бүртгэл ба уул уурхайн зөвшөөрөл; Ашигт малтмалын хайгуул; Уул уурхайн ашиглалт; Хамтын хүчээр олборлох байгууллага ба хувь хүний олборлолт зэрэг үндсэн бүлгүүдээс бүрдэнэ.

Хуулийн 4 дэх зүйлд, Төрийн өмчит уурхай нь ашигт малтмал олборлох гол этгээд мөн. Төр нь төрийн өмчит уурхайн бэхжил, дэвшлийг батлан даана гэж заажээ.

5 дахь зүйлээр, Төр нь хайгуул болон олборлолт явуулах эрхийг худалдан авах зарчимд тулгуурласан системийг нэвтрүүлнэ; гэвч тухайн нөхцөл байдалд тохируулан татварыг бууруулах, эсвэл авахгүй байхаар шийдвэрлэж болохоор зохицуулжээ. Уурхай бүр холбогдох төрийн зохицуулалтын дагуу нөөцийн татвар болон нөөцийн нөхөн төлбөрийг төлөх үүрэг хүлээнэ.

Хуулийн 20-р зүйлд, Төрийн зөвлөлийн холбогдох эрх бүхий газар зөвшөөрөөгүй бол доорх газруудад ашигт малтмал олборлохгүй:

1. Боомт, нисэх буудал болон батлан хамгаалах объектын дотор;
2. Чухал үйлдвэрлэлийн бүсээс тодорхой зай хүртэлх, том хэмжээний ус нөөцлөх төсөл, байгууламж, хотын инженерийн байгууламжийн дотор;
3. Төмөр зам, чухал хурдны авто замаас тодорхой зайнд;
4. Гол мөрөн, чухал суваг шуудуунаас тодорхой зайнд;
5. Төрийн хамгаалалттай дархан цаазат нутаг, гол байгалийн үзэсгэлэнт газар, түүхэн шүтээнт газар, үл хөдлөх түүхийн үнэ цэнэтэй газар;
6. Төрөөс өмнө нь зөвшөөрөгдсөн уурхайн газар.

22-р зүйлд, Ашигт малтмалын хайгуул болон олборлолт явуулж буй хэн боловч геологийн ховор олдвор, эсвэл шинжлэх ухаан, соёлын илэрхий үнэ цэнэ бүхий соёлын шүтээн олбол түүнийг хамгаалалтанд авах ба холбогдох газарт цаг алдалгүй мэдэгдэнэ гэж заажээ.

32-р зүйлд, Уул уурхайн салбарт ажиллаж байгаа хүн бүр байгаль орчныг хамгаалах болон байгаль орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх тухай хуулийн холбогдох заалтуудыг сахиж мөрдөх үүрэгтэй гэж заасан.

Хүн бүр газрыг арвич хямгач ашиглана. Уулын ажлын үр дүнд тариалангийн талбай, бэлчээр, эсвэл ой мод гэмтсэн бол холбогдох байгууллага нь мод тарих, өвс суулгах, эсвэл бусад аргаар тухайн газрыг сэргээх үүрэгтэй.

¹³¹www.lehmanlaw.com/resource-centre/laws-and-regulations/

Ашигт малтмалын олборлолтоос үүдэн бусдын үйлдвэрлэл болон амьдралд хохирол учруулсан хүн бүр нөхөн олговор олгох хариуцлага хүлээх буюу сэргээн засварлах үүрэг хүлээнэ.

33-р зүйлд, Төмөр зам, үйлдвэр, нөөц хадгалах байгууламж, нефтийн хоолой, өндөр хүчдэлийн шугам, эсвэл том хэмжээний барилга байгууламж барихаас өмнө барилга угсралтын байгууллага нь геологи, эрдэс баялаг хариуцсан эрх бүхий газраас эрдэс баялгийн тархалт, олборлолтын талаар мэдээлэл авсан байх шаардлагатай гэж тусгажээ. Эрх бүхий газраас зөвшөөрөл аваагүй бол ийм барилга байгууламж нь чухал орд газрыг хамарч болохгүй.

АВСТРАЛИ УЛС

Австралийн хувьд муж болгон байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, хариуцлага хүлээлгэх асуудлыг зохицуулдаг тусдаа хуультай байдаг.

Тухайлбал, **New South Wales** буюу Австралийн зүүн өмнөд мужид *Байгаль орчны үйл ажиллагааг хамгаалах тухай хуулиар*¹³² (*Protection of the Environment Operation Act 1997*) зохицуулдаг.

Уг хуулиар байгаль орчинд учруулсан хохирол буюу байгаль орчны гэмт хэргийг 3 түвшинд авч үздэг бөгөөд торгууль, шийтгэлийн хэмжээ нь эдгээр түвшинээс хамаарна.

1-р түвшиний гэмт хэрэг хамгийн ноцтой нь бөгөөд дараах үйлдлүүдийг хамруулна. Үүнд:

- санаатайгаар, эсвэл санамсаргүй үйлдлээр хог хаягдал хаяж байгаль орчныг бохирдуулах;
- санаатай болон санамсаргүй үйлдлээр бодис асгарсны улмаас байгаль орчинд хор хохирол учруулах;
- санаатай болон санамсаргүй үйлдлээр Озон хамгаалах тухай журмыг зөрчих буюу озон задлагч бодисын нөлөөгөөр байгаль орчинд хор хохирол учруулах зэрэг болно.

Эдгээр тохиолдолд 5 сая доллар хүртэл мөнгөн торгууль болон 7 жилийн хорих ялаар шийтгүүлнэ.

2-р түвшинд байгаль орчны дунд зэргийн ноцтой гэмт хэргүүд багтана. Үүнд:

- ус бохирдуулах;
- агаар бохирдуулах;
- чимээ шуугиан;
- хог хаягдал хаях, хууль бусаар тээвэрлэх, хог хаягдал хадгалах зорилгоор хууль бусаар газрын зөвшөөрөл олгох
- газар бохирдуулах зэрэг орно.

2-р түвшиний гэмт хэргийн хувьд байгаль орчин бохирдуулсан тухай мэдэгдлийг үл ойшоосон тохиолдолд корпораци дээд тал нь 2 сая доллар хүртэл, хувь хүн 500000 долларын мөнгөн торгуулиар шийтгүүлэх юм. Бусад тохиолдолд байгууллагад дээд тал нь 1 сая доллар, хувь хүнд 250000 долларын мөнгөн торгууль ногдуулна.

¹³²Protection of the Environment Operation Act 1997. www.epa.nsw.gov.au/

3-р түвшиний гэмт хэрэг буюу байгаль орчинд учруулсан хохирол нь харьцангуй хөнгөнд тооцогддог бөгөөд түүнийг холбогдох байгууллагаас өгсөн “мэдэгдэх хуудас”-ын дагуу төлж барагдуулдаг.

Австралийн хойд нутагт энэхүү асуудлыг *Байгаль орчны гэмт хэрэг ба торгууль, шийтгэлийн тухай хуулинд (Environmental offences and penalties act)*¹³³ тусгасан байна. Хуулиар байгаль орчны гэмт хэрэг буюу байгаль орчинд учруулсан хохирлыг 4 түвшинд ангилж үздэг. Үүнд:

- 1-р түвшинд, хувь хүн бол 385-3850 торгуулийн нэгжээр, эсвэл 5 жил хүртэл хорих ялаар шийтгүүлнэ. Харин корпорацийн хувьд 1924-19240 торгуулийн нэгжээр (penalty unit) торгуулдаг.
- 2-р түвшинд, хувь хүн 154-1540 торгуулийн нэгжээр, корпораци 770-7700 торгуулийн нэгжээр шийтгүүлнэ.
- 3-р түвшинд, хувь хүн 770-7700 торгуулийн нэгжээр, корпораци 385-3850 торгуулийн нэгжээр торгууль төлнө.
- 4-р түвшинд, хувь хүн 77 торгуулийн нэгж хүртэл, корпорацийн хувьд 385 торгуулийн нэгж хүртэл торгууль төлөх шийтгэлтэй.

Өнөөдрийн байдлаар Австралийн хойд нутагт 1 торгуулийн нэгж 149 доллартай тэнцүү байна¹³⁴.

*Жич: penalty unit буюу торгуулийн нэгж нь хууль, журам зөрчсөний улмаас мөнгөн торгууль төлөх тохиолдолд мөнгөний хэмжээг тооцоход хэрэглэдэг нэгж юм. Энэ нь Австралийн муж бүрийн хувьд ялгаатай байдаг. Жишээ нь: New South Wales буюу Австралийн зүүн өмнөд мужид 1 торгуулийн нэгж 110 доллар байхад, Queensland 113.85 доллар байна*¹³⁵.

3 ба 4-р түвшиний хохирлыг шүүхийн шийдвэрээр бус, цагдаагийн байгууллага болон бусад холбогдох байгууллагын “мэдэгдэгдэх хуудас”-аар төлж барагдуулах боломжтой бөгөөд энэ тохиолдолд торгууль, шийтгэлийг дараах байдлаар ногдуулна. Үүнд:

- 3-р түвшинд хувь хүн 1.7 торгуулийн нэгжээр, корпораци 8.8 торгуулийн нэгжээр торгууль төлнө.
- 4-р түвшинд хувь хүн 0.8 торгуулийн нэгжээр, корпорацийн хувьд 4.4 торгуулийн нэгж байна.

Бусад мужуудын хувьд байгаль орчныг бохирдуулсны улмаас хүлээх хариуцлага, шийтгэлийн талаарх зохицуулалтыг байгаль орчныг хамгаалах тухай хууль бүрт оруулсан байна. Жишээ нь, Өмнөд Австралийн Цэвэр агаарын тухай хуулийг (*Clean Air Act 1984*) зөрчвөл корпорацийн хувьд дээд тал нь 15000 доллар хүртэл, хувь хүн дээд тал нь 8000 доллар хүртэл мөнгөн торгууль төлнө¹³⁶.

Queensland мужийн Чимээ шуугиантай тэмцэх тухай хуулийг (*Noise Abatement Act 1978*) зөрчвөл 5000 доллар хүртэл мөнгөн торгуулийн шийтгэл хүлээх бөгөөд гэмт хэрэг үргэлжилсэн өдөр болгоны хувьд 300 долларын мөнгөн торгууль төлөх юм¹³⁷.

¹³³Environmental offences and penalties act. <http://notes.nt.gov.au/>

¹³⁴Northern territory of Australia., Penalty units regulations. <http://notes.nt.gov.au/>

¹³⁵http://en.wikipedia.org/wiki/Penalty_unit

¹³⁶Jennifer Norberry., Australian pollution laws ¾ offences, penalties and regulatory agencies. www.aic.gov.au/

¹³⁷Мөн тэнд

ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС

Байгаль орчинд учруулсан хохирлыг хэрхэн тооцож, нөхөн төлүүлдэг, хариуцлагыг хэрхэн ногдуулдаг талаар

ХБНГУ-ын Холбооны байгаль хамгаалах тухай хууль нь нийт 11 бүлэг 74 зүйлээс бүрдэнэ. Уг хуулийн бүлэг, зүйлийн гарчгийг дор сийрүүлэе. Үүнд:

1-р бүлэг. Ерөнхий зүйл

- 1-р зүйл. Байгаль хамгаалалт болон газар нутгийн тордолтын зорилго
- 2-р зүйл. Зорилгын хэрэгжилт
- 3-р зүйл. Төрийн байгууллагуудын ажил үүргийн хуваарилалт, эрх үүрэг, гэрээт тохиролцоонууд ба хамтын ажиллагаа
- 4-р зүйл. Нийтийн зориулалтаар талбайд явуулах үйл ажиллагааны баталгаа
- 5-р зүйл. Газар тариалан (хөдөө аж ахуй¹³⁸), ой мод болон загасны аж ахуй
- 6-р зүйл. Байгаль болон газар нутгийн¹³⁹ ажиглалт
- 7-р зүйл. Нэр томъёоны тодорхойлолт

2-р бүлэг. Газар нутгийн төлөвлөлт

- 8-р зүйл. Ерөнхий дүрэм
- 9-р зүйл. Газар төлөвлөлтийн үүрэг, агуулга; Бүрэн эрх
- 10-р зүйл. Газар нутгийн хөтөлбөрүүд, төлөвлөлтийн хүрээ
- 11-р зүйл. Газар нутгийн төлөвлөлгөө ба ногоон журмын төлөвлөгөөнүүд
- 12-р зүйл. Төлөвлөлт дэх муж улсуудын хамтын ажиллагаа/оролцоо

3-р бүлэг. Байгаль болон газар нутгийн ерөнхий хамгаалалт

- 13-р зүйл. Ерөнхий дүрэм
- 14-р зүйл. Байгаль болон газар нутгийн ашиглалт¹⁴⁰
- 15-р зүйл. Ашиглагчийн¹⁴¹ үүрэг; Ашиглахад хориглох зүйлс; Эрхзүйн хэм хэмжээний бүрэн эрх¹⁴²
- 16-р зүйл. Нөхөн сэргээх үйл ажиллагааны нөөц сан
- 17-р зүйл. Байцаан шийтгэл¹⁴³; Эрхзүйн хэм хэмжээний бүрэн эрх
- 18-р зүйл. Барилгын эрхзүйтэй харьцах нь
- 19-р зүйл. Тодорхой төрөл зүйл болон амьд байгалийн орон зайд учруулсан хохирлууд

4-р бүлэг. Байгаль болон газар нутгийн тодорхой хэсгийг хамгаалах**1-р хэсэг. Биотопын холбоо болон биотопын сүлжээ; Байгаль болон газар нутгийн хамгаалалттай хэсэг**

- 20-р зүйл. Ерөнхий дүрэм
- 21-р зүйл. Биотопын холбоо, биотопын сүлжээ
- 22-р зүйл. Байгаль болон газар нутгийн хамгаалалттай хэсгийн тайлбар
- 23-р зүйл. Байгалийн хамгаалалттай нутаг дэвсгэр¹⁴⁴
- 24-р зүйл. Үндэсний парк¹⁴⁵; Үндэсний байгалийн дурсгалт газар¹⁴⁶ (Дархан цаазат газрууд¹⁴⁷)

¹³⁸Landwirtschaft-“Хөдөө аж ахуй” гэж ерөнхий утгаар нь ойлгоно.

¹³⁹Landschaft

¹⁴⁰Eingriffe

¹⁴¹Verursacher

¹⁴²Ermächtigung zum Erlass von Rechtsordnungen

¹⁴³Verfahren

¹⁴⁴Naturschutzgebiet

¹⁴⁵Nationalparke

¹⁴⁶Nationale Naturmonumente

¹⁴⁷ГА (зохиогч)

- 25-р зүйл. Шим мандлын нөөц газар¹⁴⁸
 26-р зүйл. Газар нутгийн хамгаалалттай нутаг дэвсгэр¹⁴⁹
 27-р зүйл. Байгалийн цогцолбор газар¹⁵⁰
 28-р зүйл. Байгалийн хөшөө дурсгал¹⁵¹
 29-р зүйл. Хамгаалалттай газар нутгийн бүрэлдэхүүн хэсэг¹⁵²
 30-р зүйл. Хуулиар хамгаалагдсан биотоп¹⁵³
2-р хэсэг. “Натура 2000” сүлжээ
 31-р зүйл. “Натура 2000” сүлжээний бүтэц, хамгаалалт
 32-р зүйл. Хамгаалалттай нутаг дэвсгэр¹⁵⁴
 33-р зүйл. Хамгаалах ерөнхий журам
 34-р зүйл. Төслийн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ ба хориглох зүйлс; Үл хамруулалт
 35-р зүйл. Гентехникээр хувиргасан организм
 36-р зүйл. Төлөвлөгөө
5-р бүлэг. Зэрлэг амьтан, ургамлын төрөл зүйл, тэдгээрийн амьдрах газар орон болон биотопын хамгаалалт
1-р хэсэг. Ерөнхий журам
 37-р зүйл. Төрөл зүйлийн хамгаалалтын үүрэг зорилго
 38-р зүйл. Төрөл зүйл, амьдрах газар орон болон биотопын хамгаалалтын ерөнхий журам
2-р хэсэг. Төрөл зүйлийн ерөнхий хамгаалалт
 39-р зүйл. Зэрлэг амьтан, ургамлын төрөл зүйлийн ерөнхий хамгаалалт; Эрхзүйн хэм хэмжээний бүрэн эрх
 40-р зүйл. Уугуул бус, өөр нутаг дэвсгэрийн болон түрэмгий¹⁵⁵ төрөл зүйл
 41-р зүйл. Цахилгаан дамжуулах шугаман дахь шувууны хамгаалалт
 42-р зүйл. Амьтны хүрээлэн¹⁵⁶
 43-р зүйл. Амьтны хайсаар хүрээлсэн газар нутаг¹⁵⁷
3-р хэсэг. Төрөл зүйлийн тусгай хамгаалалт
 44-р зүйл. Тусгай хамгаалагдсан болон тодорхой ялгаатай төрөл зүйлийн журам
 45-р зүйл. Үл хамаатуулалт; Эрхзүйн хэм хэмжээний бүрэн эрх
 46-р зүйл. Нотлох үүрэг
 47-р зүйл. Баривчлах
4-р хэсэг. Хариуцах төрийн байгууллага; Амьтан, ургамлыг байршуулах
 48-р зүйл. Хариуцах төрийн байгууллага
 49-р зүйл. Гаалийн байгууллагын оролцоо; Эрхзүйн хэм хэмжээний бүрэн эрх
 50-р зүйл. Хилээр оруулах, дамжуулах, гаргахад албадан мэдүүлэх буюу Гуравдагч улсаас оруулж хонуулах;
 51-р зүйл. Гаалийн байгууллагын түр хадгалалт, улсын орлогод авах ба хураан авалт
5-р хэсэг. Мэдээлэл авах ба нэвтрэх эрх; Хураамж болон төлбөр
 52-р зүйл. Мэдээлэл авах ба нэвтрэх эрх
 53-р зүйл. Хураамж болон төлбөр; Эрхзүйн хэм хэмжээний бүрэн эрх
6-р хэсэг. Бүрэн эрх
 54-р зүйл. Эрхзүйн хэм хэмжээний бүрэн эрх
 55-р зүйл. Дотоодын хууль тогтоомж буюу олон улсын дүрэм журмыг мөрдөх; Эрхзүйн хэм хэмжээний бүрэн эрх

¹⁴⁸Biosphärenreservate¹⁴⁹Landschaftsschutzgebiete¹⁵⁰Naturparke¹⁵¹Naturdenkmäler¹⁵²Geschützte Landschaftsbestandteile¹⁵³Gesetzlich geschützte Biotope¹⁵⁴Schutzgebiete¹⁵⁵invasive¹⁵⁶Zoos¹⁵⁷Tiergehege

6-р бүлэг. Далайн байгаль хамгаалалт

...

7-р бүлэг. Байгаль болон газар нутагт амрах

59-р зүйл. Чөлөөтэй газар нутагт нэвтрэх

60-р зүйл. Хариуцлага

61-р зүйл. Усан болон эргийн бүсийг чөлөөтэй байлгах

62-р зүйл. Эдлэн газрыг бэлэн болгох

8-р бүлэг. Хүлээн зөвшөөрөгдсөн байгаль хамгаалах төрийн бус байгууллагуудын оролцоо

63-р зүйл. Оролцох эрх

64-р зүйл. Эрхзүйн туслалцаа

9-р бүлэг. Өмчийн өглөг/облигац¹⁵⁸, хөнгөлөлт

65-р зүйл. Төлбөр барагдуулах үүрэг

66-р зүйл. Давуу эрхээр худалдан авах эрх

67-р зүйл. Хөнгөлөлт

68-р зүйл. Өмчийг хязгаарлах; Нөхөн олговор ба хохирол барагдуулах

10-р бүлэг. Торгууль, шийтгэлийн журам

69-р зүйл. Торгуулийн журам

70-р зүйл. Төрийн захиргааны байгууллага

71-р зүйл. Шийтгэлийн журам

72-р зүйл. Хураах

73-р зүйл. Гаалийн байгууллагын эрх мэдэл

11-р бүлэг. Шилжилтийн болон дамжуулах үеийн журам

74-р зүйл. Шилжилтийн болон дамжуулах үеийн зохицуулалт

Хуулийн 68-р зүйлд зааснаар, энэхүү хууль болон түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан болон мөрдөгдөж буй хууль тогтоомжоос шалтгаалан буюу үл хамаатуулалт, эсвэл хөнгөлөлт чөлөөлөлт зэрэг арга хэмжээнүүдийг авсан боловч ганцаарчилсан тохиолдолд үндэслэлтэй хүндрэл учруулан хөрөнгийг хязгаарласан бол тохирсон нөхөн олговор олгоно. Уг зүйлийн 2-р хэсэгт, Нөхөн олговрыг мөнгөн дүнгээр барагдуулна. Дахин давтагдах байдлаар барагдуулж болно. Хэрэв эдийн засгийн хувьд үр ашиггүй аж ахуй үлдэнэ гэж үзвэл өмчийн эзэн эдлэн газрыг авахыг шаардах эрхтэй. Энэ тохиолдолд Газрын хуулиар нарийвчлан зохицуулна гэж заажээ.

Хуулийн 69-р зүйлд торгууль ногдуулах хэв журмын зөрчлүүдийг хуулийн зүйл заалт бүрээр тодорхойлжээ. Хэв журмын зарим зөрчил гаргавал 50 мянган евро хүртэл, бусад зөрчлийн хувьд 100 мянган евро хүртэл хэмжээгээр тус тус торгохоор заасан байна.

Хуулийн 71-р зүйлд зааснаар, зарим зөрчилд аж ахуйн зориулалтаар буюу дадаж занших хүртлээ үйлдсэн бол 3 хүртэл жилээр хорих буюу мөнгөн шийтгэл, заримд нь 5 хүртэл жилээр хорих буюу мөнгөн шийтгэл, дээрх зөрчлийг аж ахуйн зориулалтаар буюу дадаж занших хүртлээ үйлдсэн бол 3 сараас 5 жил хүртэл хорих шийтгэл, харин санамсаргүй үйлдсэн бол 1 жил хүртэл хугацаагаар хорих буюу мөнгөн шийтгэл тус ногдуулна.

Хуулийн 69-р зүйлийн 1-5 дахь хэсэгт заасан зөрчил гаргасан буюу 71-р зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн бол зөрчил буюу гэмт хэрэгт холбогдох эд зүйлс болон үйлдэх буюу бэлтгэхэд ашигласан эд зүйлсийг хураан авна (улсын орлого болгоно¹⁵⁹). Энэ тохиолдолд Хэв журмын зөрчлийн тухай хуулийн 23-р зүйл, Эрүүгийн хэргийн тухай хуулийн 74-р зүйлийн “а” дахь хэсгийг тус тус хэрэглэнэ.

¹⁵⁸Bindung¹⁵⁹ГА (зохиогч)

ХБНГУ-д Бавар муж улсын Дотоод хэргийн, Эдийн засаг, Дэд бүтэц, Зам тээвэр болон Технологийн, Байгаль орчин болон Эрүүл мэндийн сайд нарын хамтран баталсан “Байгаль орчны хамгаалалт” сэдэвт мөнгөн торгуулийн каталоги гэдэг журмыг 2011.12.01-ний өдрөөс эхлэн мөрдүүлж байна.

Уг журамд байгаль орчны эсрэг хэв журмын зөрчилд ногдуулах мөнгөн торгуулийн болон сануулах арга хэмжээ, прокурорт шилжүүлэн өгөх, давж заалдсаны дараах процесс зэргийг тодорхойлноос гадна санамсаргүй (хайнга) үйлдэл, хураах болон өмчлөлөөс салгахад баримтлах үндсэн зарчмыг тусгажээ. Мөн нэг удаагийн (дан) болон олон удаагийн (давтан) гэмт үйлдэл, тодорхой хүмүүсийн бүлэг (эвсэл холбоод)-ийн талаар тусгайлан зааварлажээ.

Байгаль орчны эсрэг хэв журмын зөрчлүүдийг доорх салбаруудад ангилан хувааж үзжээ. Үүнд:

- Хог хаягдал зайлуулах,
- Хөрс хамгаалалт ба хур хаягдал¹⁶⁰,
- Эмисийн хамгаалалт¹⁶¹ (Агаарын бохирдол),
- Усны ай савын хамгаалалт¹⁶²,
- Байгаль хамгаалалт болон газар нутгийн тордол¹⁶³,
- Гений инженерчлэл¹⁶⁴.

Журамд мөнгөн торгуулийн хэмжээг 20-50,000 еврогийн хооронд байхаар тогтоожээ.

* * *

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Natural Environment conservation act. <http://elaw.klri.re.kr/>
- ФЗ “О защите окружающей среды”. <http://base.garant.ru/>
- Кодекс об административных правонарушениях (КоАП РФ). <http://base.garant.ru/>
- Уголовный кодекс (УК РФ). <http://base.garant.ru/>
- БНХАУ-ын байгаль орчныг хамгаалах тухай хууль. www.china.org.cn/english/
- БНХАУ-ын ашигт малтмалын тухай хууль. www.lehmanlaw.com/
- Методические указания по оценке и возмещению вреда, нанесенного окружающей природной среде в результате экологических правонарушений. base.consultant.ru
- Постановление Правительства РФ от 26.11.2007 г. N 273 «Об утверждении такс для исчисления размера взысканий за ущерб, причиненный лесному фонду и не входящим в лесной фонд лесам нарушением лесного законодательства РФ». base.consultant.ru
- Jennifer Norberry., *australian pollution laws ¼ offences, penalties and regulatory agencies.* www.aic.gov.au/
- Protection of the Environment Operation Act 1997. www.epa.nsw.gov.au/
- Холбооны байгаль хамгаалах тухай хууль - Bundesumweltschutzgesetz. www.schleswig-holstein.de/
- “Байгаль орчин хамгаалах” сэдэвт мөнгөн торгуулийн каталог - ViaUgeldkatalog „Umweltschutz“. www.stmuv.bayern.de/

¹⁶⁰Altlasten

¹⁶¹Immissionsschutz

¹⁶²Gewdsserschutz

¹⁶³Naturschutz und Landschaftspflege

¹⁶⁴Gentechnik